

# СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.21 №36 (36)

ҮЙЛ ЯВДАЛ

## Д.Ганзориг: ЗЭВСЭГТ ХҮЧИНД ЖИЖИГ АСУУДАЛ ГЭЖ БАЙДАГГҮЙ

ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг өчигдөр Зэвсэгт хүчний өнөөгийн үйл ажиллагаа болон цаг үеийн асуудлаар сэтгүүлчдэд мэдээлэл өглөө.



Тэрээр мэдээлэлдээ “Сүүлийн үед Зэвсэгт хүчнийг улс төржүүлж байгаатай холбогдуулан тайлбар өгөхийг хүссэн юм. Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн асуудал болох Зэвсэгт хүчний эрх зүйн орчны шинэчлэл, бүтэц, зохион байгуулалтыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлэх арга хэмжээг үе үеийн төр, засгийн удирдлага, БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд авч хэрэгжүүлж ирсэн.

Бид сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, цахим орчинд цацагдсан цэргийн алба хаагчийн амь насыг хохироосон, мөн цэргийн алба хаагчид хоорондоо ёс зүйгүй харилцсан зэрэг гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийн үндсэн шалтгааныг тодруулж, түүнийг бүрэн таслан зогсоохын тулд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж, төрийн хууль тогтоомж, цагийн дүрмийн хэм хэмжээг чанд сахиулахад онцгой анхаарч ажиллаж байна.

Өнөөгийн тайван цагт Зэвсэгт хүчин оршин байхын учир нь Монгол Улсын аюулгүй байдлын гадаад, дотоод орчныг хангах, болзошгүй халдлага, түрэмгийллийг тогтоон барих, орчин цагийн байлдаан, зэвсэгт мөргөлдөөнд шаардагдах бүхэнд цэргийн алба хаагчдаа сургаж бэлтгэх, байлдааны байнгын бэлэн байдлыг хангах явдал юм. Өдгөө Монгол Улсын Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг аюулгүй байдлын орчны өөрчлөлт, дэлхийн жишгт нийцүүлэн улам бүр боловсронгуй болгон хөгжүүлж байна.

Монгол цэрэг боловсрол, дадлага, мэргэжлийн үр чадвар,

авхаалж самбаа, тэсвэр хатуужил, сахилга, зохион байгуулалтаараа өнөөдөр олон улсын түвшинд хүрч, “Монгол цэрэг бол Дэлхийн цэрэг” хэмээн үнэлэгдэж чадсан. Яг энэ цаг мөчид гэхэд дэлхийн халуун цэгүүдэд манай Зэвсэгт хүчний 1100 гаруй цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгааг цохон тэмдэглэх нь зүйтэй. Дэлхийн улс орнуудыг хамарсан “Ковид-19” цар тахлаас манай улс ангид байж чадаагүй. Өнөөдрийн байдлаар Зэвсэгт хүчний 225 цэргийн алба хаагч хөдөө, орон нутагт цар тахалтай тэмцэх тэмцэлд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран оролцож байна. Мөн Цэргийн төв эмнэлгийн бие бүрэлдэхүүн “Ковид-19” вирусээр өвчилсөн иргэдийг эмчилж, ард иргэдийнхээ эрүүл энхийн манаанд өдөр шөнийг ялгалгүй зогсож байна.

Зэвсэгт хүчин нь аливаа улс төрөөс ангид байж, улс орны аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн зохицуулалттай. Зэвсэгт хүчний тухай хуулийн 17.1, 17.2-т Зэвсэгт хүчинд улс төрийн нам, улс төрийн зорилготой олон нийтийн, шашны байгууллага байгуулах, цэргийн алба хаагч болон Хөдөлмөрийн тухай хуулиар ажиллаж буй иргэн улс төрийн үйл ажиллагаа явуулахыг тус тус хориглосон байдаг. Мөн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын дөрвөн зарчмын нэг нь улс төрийн үйл ажиллагаанаас ангид байхыг ч тусгасан. Гэвч сүүлийн үед Зэвсэгт хүчний үйл ажиллагааг улс төртэй холбож, олон нийтэд сөрөг мэдээ, мэдээлэл цацах нь хууль зөрчиж байгаа үйлдэл бөгөөд улсын батлан

хамгаалах чадавхыг бууруулах, төр засаг, Зэвсэгт хүчиндээ итгэх иргэд, олон нийтийн итгэлийг алдагдуулах, цаашлаад үндэсний аюулгүй байдал алдагдах, гаднын улс орнуудын өгөөш болох аюултай байдлыг бүрдүүлдэг гэдгийг байнга санах нь зүйтэй.

Энэ зарчим зөрчигдөж, Зэвсэгт хүчинд улс төржүүлэх, улс төрийн үйл ажиллагаа, хямралдаа цэрэг, армийг татан оруулснаар иргэний дайнд хүргэж улс орноо мөхөөх хүртэл гашуун сургамж олон улсын түүхэнд олонтаа тохиолдож байсан. Энэхүү гашуун түүх манай оронд битгий тохиолдоосой гэдгийг Монгол Улсын ЗХЖШ-ын даргын зүгээс хүсэх байна.

Намайг ЗХЖШ-ын даргын албан тушаалд томилогдоход УИХ-ын гишүүд ч улс төрөөс ангид байхыг онцгойлон хэлж, ялангуяа тухайн үед байгуулагдаад, үйл ажиллагаа нь идэвхжиж байсан “Үндэсний фронт” хөдөлгөөнд бэлтгэл цэргийн алба хаагчид олноор хамрагдаж байгааг буруутгаж, ийм байдлаас ангид байхыг захиж байсан. Гэхдээ өнөөдөр нөхцөл байдлыг эргээд харахад өөр байна. Тухайлбал, Монгол Цэргийн Нэгдсэн холбоо гэдэг байгууллагыг та бүхэн мэднэ. Энэ байгууллага анх байгуулагдахдаа цэргийн алба хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлаар эвлэлдэн нэгдэж байсан. Өдгөө эргээд харахад улс төрөөс шууд хамааралтай буюу Монгол Ардын Намын дарга ахлаад явж байна. Дүрэмдээ бол Монгол Цэргийн Нэгдсэн холбоог Ерөнхий сайд ахлан ажиллах заалттай. Энэ асуудлыг холбогдох байгууллага шийдвэрлэх байх гэж харж байна.

Түүнчлэн 2021 оны 4 дүгээр

сарын 6-ны өдөр УИХ-ын Хүний эрхийн дэд хороо Зэвсэгт хүчинд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн асуудлыг авч хэлэлцсэн. Энэ бол мэдээж сайшаалтай. Зэвсэгт хүчинд тулгамдаж байгаа асуудлыг төрийн дээд байгууллагаас шийдвэрлэх хүсэл, эрмэлзлэлтэй байна гэж харж байна. Ард түмнээс сонгогдсон УИХ-ын гишүүдийг цэргийнхэн бид хүндэтгэж явдаг. Гэхдээ Зэвсэгт хүчинтэй холбоотой асуудлыг нээлттэй хэлэлцүүлэг хийж, улс орны аюулгүй байдлыг хангах тогтолцоог гажуудуулах асуудал гаргасан гэж үзэж байна. Тухайн үед улс төрийн тоглолт хийж, улс орны батлан хамгаалах чадавхтай холбоотой асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг хийсэн нь төрийн болон албаны нууц задлах нөхцөлийг бүрдүүлсэн.

Зэвсэгт хүчинд жижиг асуудал гэж байдаггүй. Нийгмийн олон талт харилцаа, сайн муу тусгал цэргийн албыг тойроогүй. Улс төржүүлж болохгүй асуудал гэж бий. Зөрчигдвөл том төлөөсийг улс үндсээрээ төлдөг гашуун сургамжийг мартаж болохгүй. Эрхэм улс төрчид маань Зэвсэгт хүчний үйл ажиллагааг улс төржүүлэхгүй шийдвэрлэж байх нь улс үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцнэ гэдгийг ажил хариуцаж байгаагийн хувьд илэрхийлье.

Зэвсэгт хүчин хариуцлагаас зугтаагүй, эх орон, төр түмэндээ өргөсөн тангарагтаа үнэнч байна. Хууль тогтоомжийн хүрээнд гарсан шийдвэрийг Зэвсэгт хүчин хүндлэн биелүүлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч ч Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний цугларалт дээр Цэргийн байгууллага, цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаа улс төрөөс ангид байх ёстойг захиж анхааруулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Төрийн ордонд мэдэгдэл хийснийхээ дараа ЗХЖШ-т хүрэлцэн ирсэн. Бидэнд гурван чиглэлээр үүрэг өгсөн. Ерөнхийлөгчийн өгсөн чиглэлд нэгдүгээрт, цэргийн албыг сайжруулах асуудлын хүрээнд байгуулагдсан Ажлын хэсэг цэргийн анги, байгууллагуудын үйл ажиллагааг шалгах, холбогдох шийдвэр гаргах, хоёрдугаарт, орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойн хойшлогдсон арга хэмжээнүүдийг хэзээ, ямар хэлбэрээр “Ковид-19”-ийн нөхцөлтэй уялдуулан зохион байгуулах тухайд санал солилцсон. Гуравдугаарт, Монгол Цэргийн Нэгдсэн холбооны үйл ажиллагааны талаар лавлаж асуусан.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч ЗХЖШ-т ажилласан асуудлыг Монгол Ардын Намын зүгээс улс төрийн өнцгөөс холбон ярьж байгааг нь ЗХЖШ-ын зүгээс албан ёсоор ийнхүү няцааж байгааг мэдэгдье.

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
19	-4

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	24

#### АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
22	7

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.845.00	2.856.00
EUR	3.401.00	3.461.00
CNY	436.20	439.60
RUB	36.90	38.50
JPY	26.09	26.59
KRW	2.46	2.60

### ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 9  
2021.04.21.  
/ЛХАГВА ГАРАГ/

**ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ  
САРЫН ТАВАН ШАР  
ШАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин өчүүхэн ирнэ.

Наран ургах, шингэх:

05.52-19.50

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Өтлөх үхэхүй

Суудал:

Хий.

Аргын тооллын 4 дүгээр сарын 21, Буд гараг. Билгийн тооллын 9, Үнэг одтой, шарагчин гахай өдөр. Өдрийн наран 5 цаг 52 минутад мандан, 19 цаг 50 минутад жаргана. Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалаа хийлгэх, биеийн тамырыг сэрээх, сүм дуганыг сэрээх, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатагахад сайн. Газар ухах, худаг гаргах, гөлөг тэжээх, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод урагш мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

22.844+1311

ЭДГЭРСЭН

12.860

НАС БАРСАН

51/6

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

1781 (11)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

302

ЭДГЭРСЭН

1468

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 141,057,106

Эдгэрсэн

Нийт: 121,398,961

Нас барсан

Нийт: 3,015,043

### ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН

СУУЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

3175 637,415

ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/

СУУЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

10,431 2,576,921

ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО

СУУЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

2879 361,192

ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН

СУУЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

654 62,784

2021.04.20

11:00 ШУНГАН БАЙДАГ

ХАНГАА ДАВНА

ЦАХИМ ШУУДАНД

## АЖЛЫН ХЭСГИЙН АНХДУГААР ХУРАЛДААН БОЛОВ

Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлийн журам боловсруулах ажлын хэсгийн анхдугаар хуралдаан өчигдөр боллоо.

Хуралдаанаар Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны журмын төслийг хэлэлцэн ажлын хэсгүүдийн дарга, гишүүдийн нэгдсэн саналаар дахин боловсруулахаар болсон юм. Энхээр журмын төсөл батлагдсанаар Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт сайжирч, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо нэмэгдэх төдийгүй төрийн батлан хамгаалах үйлчилгээ, төрийн захиргааны байгууллагаас шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн төлөөллийн оролцоог нэмэгдүүлэх боломж нэмэгдэх давуу талтай юм. Эдгээр нь



Батлан хамгаалах бодлого, зорилт түүний хэрэгжилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг дээшлүүлэхэд чухал хөшүүрэг болох аж.

## ЦЭРГҮҮД ЦУСАА ХАНДИВЛАЛАА



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран "Цусаа хандивлаж, бусдын

амийг аваръя" аяныг зохион байгууллаа. Цар тахлын халдвар буурахгүй байгаатай холбогдуулан цусны доноруудын хандив

буурч, цусны нөөц улс орон даяар багассан энэ үед тус аян нүдээ олсон арга хэмжээ болж чадлаа.

Бусдад амьдрал бэлэглэх аянд хугацаат цэргийн алба хаагчид өөрсдийн хүсэлтээр хамрагдсанд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн мэргэжилтнүүд талархал илэрхийлж, "Эх орноо батлан хамгаалагч эр цэргүүд та нар энэ үйлсээрээ том гавьяа байгуулж байна. Бусдын алтан амийг аварна гэдэг дайны талбарт нөхөртөө тусалсантай адил баатарлаг үйлс, хэзээ ч мартагдахгүй мөнхийн гавьяа юм" хэмээн баяр хүргээд цэргийн албаа нэр төртэй хаахыг захилаа. Энэхүү аяныг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан явуулсан юм.

Хошууч Д.ХАДХҮҮ

## ЦЭРГИЙН БАЙРНЫ ШАВ ТАВИХ ЁСЛОЛ БОЛЛОО



Зэвсэгт хүчний 017 дугаар анги

Цэргийн байрны шав тавих ёслол боллоо. Ёслолын ажиллагаанд ангийн удирдлага, бие бүрэлдэхүүн оролцсон. Мөн Дашчаглин хийдийн

унзад лам Б.Удаанжаргал байгаль дэлхийгээ аргадан, ерөөл өргөн ном хурав. Энэхүү цэргийн байр нь хоёр давхар, 100 цэргийн багтаамжтай байх юм.



Коронавирусийн цар тахлын нөхцөлбайдлаас шалтгаалан барилга угсралтын ажил удаахрахгүй хэвийн явагдвал энэ намар ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

## СУРГАЛТУУДЫГ ЦАХИМААР ЯВУУЛЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Хүний эрхийн үндэсний комиссын Баян-Өлгий аймаг дахь салбартай хамтран "Хүний эрхэд суурилсан хандлага" сэдвээр цахим сургалтыг явууллаа.

Хүний эрхийн төлөөлөгч Г.Уранчимэг бие бүрэлдэхүүнд сургалтыг зохион байгуулсан бөгөөд Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу цар тахлын халдвар, хамгааллын дэглэмийг баримталж "google meet", "zoom", "classroom" зэрэг аппликейшн ашиглан зайнаас цахимаар зохион байгуулснаар онцлог боллоо.

Мөн гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бие бүрэлдэхүүний албандаа хандах хандлагыг дээшлүүлэх зорилгоор

"Хандлага өөрчилж, хариуцлагаа дээшлүүлэе" уриан дор хэд хэдэн сургалтыг санаачлан явуулав. Тухайлбал, ангийн Сургалт, соёл хүмүүжлийн албанаас "Зэвсэгт хүчний офицер ахлагчийн ёс зүй", "Цэргийн алба хаагчдын хоорондын харилцаа", "Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн тухай ойлголт", Эмнэлгийн албанаас "Согтууруулах ундааны хор уршиг" "Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга зам" зэрэг сэдвээр лекц, яриа таниулга хийсэн юм. Түүнчлэн эдгээр хичээлийг видео хэлбэрээр ажилчдын автобусны телевизороор өглөө, оройд тус бүр нэг цагийн хугацаатайгаар хамт олондоо түгээж байна.

СУРГАЛТ, СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН АЛБА

## ОЛОН ТАЛЫН МЭДЛЭГ МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ



Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

Тус ангийн сэтгэл зүйн хангалтын офицер, ахлах дэслэгч М.Очгэрэл "Харилцааны сэтгэл зүйн зарим асуудал" сэдвээр цахим сургалтыг бие бүрэлдэхүүнд энэ сарын 19-нд явууллаа.

Сургалтаар хүмүүс хоорондын харилцааны хэв шинж, үүрэг, төрөл, ач холбогдлын талаар мэдээлэл хүргэв. Мөн цэргийн алба хаагчид хоорондын харилцааны онцлог, хувь хүнийг хүндлэх, бусдыг хүлээн зөвшөөрөх зэрэг олон талын мэдлэг, мэдээлэл өгөхийг зорилоо.

Шинэ зэвсэг, техник


## ХАЙБРИД ХӨДӨЛГҮҮРИЙН СИСТЕМТЭЙ НИСДЭГ ТЭРЭГ БҮТЭЭЖ БАЙНА

Өндөр хурдны RACER (Rapid And Cost-Effective Rotorcraft) нисдэг тэрэгний туршилтын загварыг зохион бүтээх ажил ид явагдаж байна.

"Airbus" компани нь ирээдүйн нисдэг тэрэгний их биеийг угсарч байгаа бөгөөд "Safran" хайбрид нь цахилгаан хөдөлгүүрийн ачаар ердийн нисдэг тэрэгнээс 15 хувиар бага шатахуун зарцуулах бол хурдыг 400 км /цагт хүргэх юм. Тус нисдэг тэрэг 740 км-т 6-8 хүн тээвэрлэх, эмнэлгийн түргэн тусламж үзүүлэх, эрэн хайх, авран туслах, хууль сахиулах ажиллагаанд оролцох зориулалттай байх гэнэ. Энэ жилийн сүүлээр RACER-ийг Францын Марингане дахь "Airbus" компанийн "Helicopters" салбарт шилжүүлэх ба 2022 оны эцэс гэхэд угсарч, туршилтын нислэгийг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Уг нисдэг тэрэг нислэгийн үед хөдөлгүүрийнхээ аль нэгийг унтрааж, нөгөөг нь ашиглах боломжтой байхаар зохион бүтээгдэж байгаа аж.

Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн ерөнхий инженер, ахмад Э.МӨНХ-ЭРДЭНЭ



Clean Sky2  
**AIRBUS**